



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/35

Хэрлэн сум

Шагнаж, хөрөнгө зарцуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн гуравдугаар хавсралтын дагуу 2021 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр 1, 2, 3 дугаар байр эзэлсэн сумдын Засаг даргын Тамгын газрыг урамшуулахад зориулж 2.490.000 (хоёр сая дөрвөн зуун ерэн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. 1 дүгээр байр эзэлсэн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын даргыг сарын үндсэн цалингийн 80%, 2 дугаар байр эзэлсэн Дадал сумын Засаг даргын Тамгын газрын даргыг сарын үндсэн цалингийн 60%, 3 дугаар байр эзэлсэн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын даргыг сарын үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн шагналаар шагнахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010159

Аймгийн Засаг даргын 2022 оны  
01 дүгээр сарын 21 өдрийн А/35  
дугаар захирамжийн хавсралт



Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Баян-Овоо	1	1.000.000	1.000.000
2	Дадал	1	800.000	800.000
3	Бор-Өндөр	1	600.000	600.000
4	Батламж	3	30.000	90.000
<b>Дүн</b>				<b>2.490.000</b>